



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A157

Бор-Өндөр сум

Иргэний мэдээлэл залруулах хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 147 дугаар захирамжаар Боржигин овогт Энхтөрийн Чинбат (РД: ЕЦ87062271)-д газар өмчлүүлсэн захирамжид уг иргэний регистрийн дугаарыг буруу дурдсан байх тул регистрийн дугаарын зөрүү, зөрчлийг залруулсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбоотой Газрын кадастрын мэдээллийн санд иргэн Э.Чинбатын мэдээллийг үнэн зөв болгож залруулахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ